

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН  
СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ**

2025 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**“Шатахуун түгээх станц.Галын аюулгүйн норм” (БНбД 21-07-14)  
барилгын норм ба дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн 20.. оны .. дугаар сарын ...-ний өдрийн ..... дугаар хурлын шийдвэрийн дагуу Барилга, хот байгуулалтын сайдын 2014 оны 57 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Шатахуун түгээх станц.Галын аюулгүйн норм" (БНбД 21-07-14) барилгын норм ба дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2.Нэмэлт өөрчлөлт оруулж батлагдсан барилгын норм ба дүрмийг хэвлэн олшруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ (Т.Пүрэвхатан)-т, энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлогын бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Энхбаатар)-т тус тус даалгасугай.

САЙД

Э.БАТ-АМГАЛАН

“Шатахуун түгээх станц.Галын аюулгүйн норм” (БНБД 21-07-14)  
барилгын норм ба дүрэмд нэмэлт өөрчлөлтийн төсөл

1.“Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм” (БНБД 21-07-14) барилгын норм ба дүрмийн хэрэглэх хүрээ хэсгийн “... авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн” гэсний дараа “шингэн” гэснийг хасах.

2.Энэхүү норм ба дүрмийн 4.Ерөнхий зүйл бүлгийн 4.3-т “... тавигдах шаардлагыг (Хавсралт В)” гэсний дараа “(ОТТС, АХШТС ба АХТС-д тавигдах шаардлагыг Хавсралт Е-д зааснаар төлөвлөнө” гэж нэмэх.

3. Энэхүү норм ба дүрмийн 5.Байршилд тавигдах шаардлага бүлгийн 5.4 дэх заалтын 1 дүгээр хэсэгт “түгээгүүрийн их биенээс” гэснийг “түгээгүүрийн их бие” гэж өөрчлөх, “тоног төхөөрөмж” гэсний дараа “ШНУХ, ШаБХ болон шингэн түлшний” гэж, “буулгах” гэсний дараа “болон автоцистерны зогсоолын талбайн захаас” гэж тус тус нэмэх.

4. Энэхүү норм ба дүрмийн хүснэгт 1-ийн Тайлбар 1-д “Газар доор байрласан савтай ШТС-аас” гэснийг “Газар доор байрласан шатахуун түгээх станцын сав нь” гэж өөрчлөх, “барилгын С0 ба С1...” гэсний өмнө “давхар ханатай тохиолдолд” гэж, “I ба II-р зэргийн орон сууц ...” гэсний өмнө “цонх болон хаалгагүй хөндлөн хана бүхий” гэж тус тус нэмэх.

5. Энэхүү норм ба дүрмийн хүснэгт 1-ийн Тайлбар 2-т “ШТС нь аюул осол, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийн үед хөрсөнд болон талбайд шатахуун алдагдахаас бүрэн хэмжээнд урьдчилан хамгаалсан, шатахууны сав, технологийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих, хяналтыг автоматжуулсан хэрэгслүүдийн тусламжтайгаар гүйцэтгэх техник, технологитой байхаар төлөвлөсөн бол зайг 25%-аас ихгүй хэмжээгээр багасгаж болно.” гэснийг “ШТС-ын технологийн системийг төлөвлөхдөө тэсрэх аюултай хийн холимгийг саармагжуулах (флегматизаци) эсвэл технологийн тоног төхөөрөмжийн доторх ууршсан хий-агаарын хольцын тэсрэлт болон эсвэл шаталтыг таслан зогсоох системээр тоноглогосон бол заалтын зай хэмжээг 25%- аас ихгүй хэмжээгээр багасгаж болно. Үүнд: Хүснэгт 1-ийн 3, 4, 10, 11 заалт хамаарахгүй.” гэж өөрчлөх.

6. Энэхүү норм ба дүрмийн хүснэгт 1-ийн Тайлбар 3-т “ШТС-ын талбайн захаас 5 метрээс багагүй өргөнтэй гал дэмждэггүй материалаар гадаргуун хучилт хийж тусгаарласан эсвэл галын зурвас татсан тохиолдолд ШТС-ээс ойн нөөц хүртэлх зайг 2 дахин багасгахыг зөвшөөрнө.” гэж нэмэх.

7. Энэхүү норм ба дүрмийн Хавсралт Е.ОТТТС[1], АХТШС[2] ба АХТС[3]-д тавигдах нэмэлт шаардлагын 1. ОТТТС, АХТШС ба АХТС-ыг байрлуулах газарт тавигдах шаардлагын 2-т “Байгалийн” гэсний дараа “шахсан” гэж нэмэх, “шингэрүүлсэн” гэснийг хасах, “нөөцлүүр” гэсний өмнө “ШНУХ” гэж нэмэх.

8. Энэхүү норм ба дүрмийн Хавсралт Е.ОТТТС[1], АХТШС[2] ба АХТС[3]-д тавигдах нэмэлт шаардлагын II.Олон төрлийн ТТС, АХТШС ба АХТС-уудын барилга байгууламжид тавигдах шаардлагын 11.1 дэх хэсэгт “... аваарын хаялтын хувьд” гэсний дараа “бамбарын систем, түүний аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагад нийцсэн” гэж нэмэх, “ПУ ба БЭФ-91-ээр тогтоогдсон” гэснийг хасах.

9. Энэхүү норм ба дүрмийн Хавсралт Е.ОТТТС[1], АХТШС[2] ба АХТС[3]-д тавигдах нэмэлт шаардлагын II.Олон төрлийн ТТС, АХТШС ба АХТС-уудын барилга байгууламжид тавигдах шаардлагын 11.3 дахь хэсэгт “Тээврийн хэрэгслийн технологийн системийн тоног төхөөрөмжүүд, хийн баллонуудын тоног төхөөрөмжүүдээс үлээх хий мөн түүнчлэн байгалийн хий буюу ШНУХ-н уурыг олон төрлийн ТТС, АХДШС ба АХШТС-ын технологийн системээс хийг агаарт зайлшгүй гаргах шаардлагатай болсон үед (түймэр гарсан ба түймрийн аюултай нөхцөл үүсэх үед) түүнийг (нөөцлүүр сав орохгүй) хаялтын хоолойгоор дамжуулан гаргах боломжийг урьдчилан төлөвлөсөн байна.” гэснийг “ТТС, АХДШС ба АХШТС-ын технологийн систем (нөөцлүүр сав орохгүй), тээврийн хэрэгслийн хийн баллоны төхөөрөмжөөс үлээлгэн цэвэрлэх хий, байгалийн хий, ШНУХ уурыг агаарт зайлшгүй гаргах шаардлагатай болсон үед (гал гарсан ба галын аюултай нөхцөл үүсэн үед) түүнийг хаялтын хоолойгоор дамжуулан гаргах боломжийг урьдчилан төлөвлөсөн байна.” гэж өөрчлөх.

10. Энэхүү норм ба дүрмийн 20-д “... ТТС-ын технологийн” гэсний дараа “хэсэг, ба” гэснийг хасах, “талбайн төлөвлөлт, мөн” гэж нэмэх.

11. Энэхүү норм ба дүрмийн 20.ШНУХ-г хүлээн авч, хадгалах, түгээх зориулалттай олон төрлийн ТТС-ын технологийн хэсэг, ба олон төрлийн ТТС бие даасан хэсэгтэй АХТС-д тавигдах шаардлагын 20.1-д “газар дор” гэсний дараа “байрлуулж” гэж, “зузаан” гэсний дараа “шороогоор хучсан” гэж тус тус нэмэх, “газрын бүсэд байрлах” гэсний өмнөх “хүн ам оршин суух” гэснийг “хот суурин” гэж “... нэгж савны багтаамж нь” гэснийг “нэг савны багтаамж нь” гэж тус тус өөрчлөх.